



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/662

Арвайхээр

**Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг
сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.8, 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 385 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 41 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101400